



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/148/СТА-ТШЗ

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас:70442584 Цахим хаяг:munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг:tseenyama@ audit.gov.mn

Аудитор:Д.Энхтуяа

Утас:99449299 Цахим хаяг:tomoo_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

| | |
|--|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| 2.1. Оршил | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд..... | 7 |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .. | 8 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл..... | 8 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт..... | 9 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 9 |
| 3. Менежментийн захидал..... | 10 |
| 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 12 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 13 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 17 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 17 |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/284

танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Г ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитындээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

• 005020250

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Д:Абичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Содномчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 23 ноос 2020 оны 02 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймгийн “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн .11....дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийг тайлант хугацаанд Сургуулийн өмнөх боловсрололгох эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, тогтолцооны шинэчлэл хийх
- Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах
- Боловсрол, соёл урлаг спортын менежмент, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх
- Төсвийн удирдлага, хэрэгжилтийн чанарыг сайжруулах зорилтууд дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Аcolous программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны Здугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож,

эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 235425.5 мянган төгрөгөөс 2,0 хувиар тооцон 4708.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6374.4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд 3 улирлын сонгосон суурийг жилийн эцсийн үр дүнгээр өөрчилсөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4592,3 мянган төгрөгөөр буюу 0,5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|-------------------|--------------------|----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 532.1 | 1017,5 | 485,4 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | | 0 |
| Бараа материал | 44058.2 | 51224.7 | 7166.5 |
| Үндсэн хөрөнгө | 1033070,3 | 1038865,4 | 5795,1 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | -92998,6 | -111037,8 | -18039,2 |
| Нийт хөрөнгө | 984662.1 | 980069,9 | -4592,2 |
| Өр төлбөр | 680.3 | 2043.1 | 1362.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 983981.8 | 978026,8 | -5955,0 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 984662.1 | 980069,9 | -4592,2 |

Бараа материалын дансны үлдэгдэл 7166,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 72921,7 мянган төгрөгийн худалдан авалт хийж, орлого авч 65755,2 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5795,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 5795,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, орлогот авснаас шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгөнд 7480,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 978026,7 мянган төгрөг болжбуурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлттэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулантусгай зориулалтын шилжүүлгээс 284130.5 мянган, орон нутгийн төсвөөс 26818.3 мянган, нийт 310948.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч 310673,6 мянган төгрөгийг зарцуулан төсвийн хэмнэлтийн 275,2 мянган төгрөгөөс орон нутагт 264,6 мянга, улсын төсөвт 10,6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэлТЗШ-ийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг батлагдсан хэмжээнд авч, 310673,5 мянган төгрөгийг зарцуулан тусгай зориулалтын шилжүүлгээс зарцуулаагүй үлдэгдэл 10.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 310673,5 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна.

Нэмэлт төсөв:Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого байхгүй байна

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 21248,0 мянган төгрөгийн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардалд гүйлгэн бичсэн алдаа, зөрчил илэрсэнд санхүүгийн тайланд залруулга хийв

Аудитаар эд хөрөнгийн тооллогыг чанартай хийх, өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж мөрдөөгүй зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогтсумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасанмэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|-----|------------|-------|------|--------------------|-------------------|------------------|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 3 | 3 | 5 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 3 | 1 | |
| 3 | Улирал бүр | 4 | 4 | 2 | 2 | |
| 4 | Сар бүр | 36 | 36 | 34 | 2 | |
| 5 | Тухай бүр | 96 | 96 | 70 | 26 | |
| | Нийт | 151 | 151 | 112 | 34 | 5 |

Нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас 34 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрдэнэцогтсумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтболон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Тооллогын комисс томилогдсон боловч тооллогын бүртгэлийг холбогдох батлагдсан маягтаар үйлдэж албажуулж гарын үсэг зураагүй, тооллогын үр дүнг хэлэлцээгүй, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүйгээс 2019 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг чанар муутай хийсэн гэх бүрэн үндэслэл байна

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлсэн акт бүрэн биш, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг чанар муутай хийсэн байна Энэ нь НББ-ын тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн заалтуудыг зөрчсөн

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлд өглөг авлага үндэслэлгүй нэмэгдэх, эд хөрөнгө дутагдах, шамшигдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж, тооллогыг дахин чанартай хийж үр дүнг баталгаажуулж, сар бүр бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо нийлж, үлдэгдлийг батлагдсан маягтаар тооцоо бодсон актаар баталгаажуулж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 44,590,424.30 | 52,242,225.87 |
| 33 | АВЛАГА | 532,163.00 | 1,017,482.97 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 485,319.97 |
| 335 | Бусад авлага | 532,163.00 | 532,163.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 532,163.00 | 532,163.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 44,058,261.30 | 51,224,742.90 |
| 354 | Хангамжийн материал | 44,058,261.30 | 51,224,742.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 60,000.00 | 119,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 42,895,892.90 | 48,715,642.90 |
| 35460 | Хүнсний материал | 1,102,368.40 | 1,152,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 1,237,500.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 940,071,683.61 | 927,827,627.14 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 940,071,683.61 | 927,827,627.14 |
| 392 | Биет хөрөнгө | 932,591,683.61 | 920,347,627.14 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 969,395,186.90 | 969,395,186.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -49,880,280.45 | -66,030,848.13 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 20,410,114.00 | 21,310,114.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17,709,072.62 | -18,493,252.45 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,675,998.00 | 38,571,098.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -25,209,262.22 | -26,313,671.18 |
| 39217 | Ном | 1,909,000.00 | 1,909,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 984,662,107.91 | 980,069,853.01 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 680,301.00 | 2,043,101.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 680,301.00 | 2,043,101.00 |
| 413 | Өглөг | 680,301.00 | 2,043,101.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,362,800.00 |
| 4136 | Бусад өглөг | 680,301.00 | 680,301.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 680,301.00 | 680,301.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 983,981,806.91 | 978,026,752.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 983,981,806.91 | 978,026,752.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -14,737,067.62 | -20,692,122.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -14,737,067.62 | -14,737,067.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5,955,054.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 898,281,958.42 | 898,281,958.42 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 984,662,107.91 | 980,069,853.01 |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 274,109,925.00 | 312,756,830.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19,284,500.00 | 00.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,284,500.00 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19,284,500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,284,500.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,759,725.00 | 28,626,330.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 245,065,700.00 | 284,130,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 245,065,700.00 | 284,130,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,545,522.00 | 1,364,908.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 1,364,908.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,545,522.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 26,818,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 26,818,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 8,214,203.00 | 443,122.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 8,214,203.00 | 443,122.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 262,937,552.93 | 318,711,884.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 262,937,552.93 | 318,711,884.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 237,781,740.93 | 316,546,641.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 140,191,280.80 | 186,797,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,191,280.80 | 184,730,591.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 2,066,509.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,438,747.00 | 23,375,680.03 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,438,747.00 | 11,145,832.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 2,999,516.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 2,427,183.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 587,261.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 6,215,888.03 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,747,963.00 | 23,679,017.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,696,547.00 | 1,571,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,831,416.00 | 21,907,917.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 220,000.00 | 200,000.00 |

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,436,270.00 | 6,730,720.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 737,000.00 | 1,382,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,035,162.00 | 540,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 239,735.00 | 1,021,550.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 110,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,516,973.00 | 3,497,150.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,907,400.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 44,699,855.00 | 46,410,868.40 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,600.00 | 38,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,593,655.00 | 46,372,868.40 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 70,600.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 00.00 | 10,754,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 10,754,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 78,400.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 78,400.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 200,000.00 | 560,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 360,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,989,225.13 | 18,169,156.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 515,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 130,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,474,225.13 | 18,039,156.47 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,155,812.00 | 2,165,243.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,113,473.00 | 525,122.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 8,214,203.00 | 443,122.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,599,270.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 82,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 42,339.00 | 10,630.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,339.00 | 10,630.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 11,172,372.07 | -5,955,054.90 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 11,172,372.07 | -5,955,054.90 |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 254,825,425.00 | 312,756,830.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 254,825,425.00 | 312,756,830.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 245,065,700.00 | 284,130,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 245,065,700.00 | 284,130,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,545,522.00 | 1,364,908.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 1,364,908.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,545,522.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 26,818,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 26,818,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 8,214,203.00 | 443,122.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 8,214,203.00 | 443,122.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 254,825,425.00 | 306,961,730.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 254,825,425.00 | 306,961,730.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 229,651,913.00 | 304,796,487.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 139,517,684.00 | 186,897,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 128,026,384.00 | 162,305,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,045,500.00 | 12,917,300.00 |
| 210104 | Урамшуулал | 6,445,800.00 | 11,674,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,249,344.00 | 23,761,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,035,344.00 | 16,753,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,384,000.00 | 1,746,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,042,900.00 | 1,402,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 260,500.00 | 350,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,526,600.00 | 3,507,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,820,853.00 | 23,553,717.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,366,147.00 | 1,571,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,234,706.00 | 21,782,617.00 |

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210303 | Цэвэр, бохир ус | 220,000.00 | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,944,097.00 | 14,555,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 56,700.00 | 74,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 382,709.00 | 440,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,109,388.00 | 1,367,040.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 20,000.00 | 41,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 375,300.00 | 12,452,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 45,245,830.00 | 47,082,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,600.00 | 38,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,835,930.00 | 46,423,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 374,300.00 | 621,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 778,500.00 | 6,981,900.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 4,994,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 778,500.00 | 1,987,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 78,400.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 78,400.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,235,222.00 | 497,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,235,222.00 | 297,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,781,983.00 | 1,396,630.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 987,383.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 794,600.00 | 1,396,630.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,173,512.00 | 2,165,243.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,131,173.00 | 525,122.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 8,214,203.00 | 443,122.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,333,270.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,583,700.00 | 82,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 1,629,491.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,629,491.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 42,339.00 | 10,630.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,339.00 | 10,630.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 5,795,100.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 5,795,100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 5,795,100.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 5,795,100.00 |

**Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| | | | |
|--------|--|--------------|----------------------|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 5,795,100.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -5,795,100.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 100,436,916.11 | 898,281,958.42 | -14,737,067.62 | 983,981,806.91 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 100,436,916.11 | 898,281,958.42 | -14,737,067.62 | 983,981,806.91 |
| D03 | Тайлант үеийн үр дүн | | | -5,955,054.90 | -5,955,054.90 |
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 100,436,916.11 | 898,281,958.42 | -20,692,122.52 | 978,026,752.01 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 227,993,800.00 | 227,760,963.00 | 310,948,800.00 | 310,673,587.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 227,993,800.00 | 227,760,963.00 | 310,948,800.00 | 310,673,587.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 223,710,000.00 | 223,477,963.00 | 310,865,900.00 | 310,591,587.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 133,836,600.00 | 133,747,430.00 | 186,897,100.00 | 186,897,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 122,063,000.00 | 122,010,284.00 | 162,305,400.00 | 162,305,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,045,500.00 | 5,009,141.00 | 12,917,300.00 | 12,917,300.00 |
| 210104 | Урамшуулал | 6,728,100.00 | 6,728,005.00 | 11,674,400.00 | 11,674,400.00 |

**Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| | | | | | |
|-------------|--|---------------|---------------|---------------|---------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,764,900.00 | 14,658,358.00 | 23,761,000.00 | 23,761,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,764,900.00 | 14,658,358.00 | 16,753,900.00 | 16,753,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 1,746,000.00 | 1,746,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 1,402,900.00 | 1,402,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 350,800.00 | 350,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 3,507,400.00 | 3,507,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,854,800.00 | 20,842,720.00 | 23,818,300.00 | 23,553,717.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,366,200.00 | 1,366,200.00 | 1,571,100.00 | 1,571,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,288,600.00 | 19,276,520.00 | 22,047,200.00 | 21,782,617.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 | 200,000.00 | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,439,400.00 | 1,426,136.00 | 16,656,200.00 | 16,655,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 75,600.00 | 75,500.00 | 74,900.00 | 74,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 390,000.00 | 388,445.00 | 440,000.00 | 440,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 556,400.00 | 545,491.00 | 1,367,500.00 | 1,367,040.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 41,900.00 | 41,200.00 | 41,400.00 | 41,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 180,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 375,500.00 | 375,500.00 | 14,552,400.00 | 14,552,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 50,622,800.00 | 50,615,505.00 | 48,583,300.00 | 48,582,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,000.00 | 39,000.00 | 38,700.00 | 38,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,083,800.00 | 45,076,505.00 | 46,423,100.00 | 46,423,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зоолон эдлэл | 5,500,000.00 | 5,500,000.00 | 2,121,500.00 | 2,121,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 128,200.00 | 127,900.00 | 9,177,100.00 | 9,177,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 6,050,000.00 | 6,050,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 128,200.00 | 127,900.00 | 3,127,100.00 | 3,127,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 78,400.00 | 78,400.00 | 77,600.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 78,400.00 | 78,400.00 | 77,600.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 389,500.00 | 388,757.00 | 497,800.00 | 497,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 389,500.00 | 388,757.00 | 297,800.00 | 297,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 200,000.00 | 200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1595400.00 | 1592757.00 | 1397500.00 | 1396630.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 669,600.00 | 668,922.00 | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 925,800.00 | 923,835.00 | 1,397,500.00 | 1,396,630.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4283800.00 | 4283000.00 | 82900.00 | 82000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,283,800.00 | 4,283,000.00 | 82,900.00 | 82,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,200,000.00 | 4,200,000.00 | 00.00 | 00.00 |

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|---|----------------|----------------|----------------|----------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 83,800.00 | 83,000.00 | 82,900.00 | 82,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 227,993,800.00 | 227,760,963.00 | 310,948,800.00 | 310,673,587.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 227,993,800.00 | 227,760,963.00 | 284,130,500.00 | 284,119,870.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 227,993,800.00 | 227,760,963.00 | 284,130,500.00 | 284,119,870.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 00.00 | 26,818,300.00 | 26,553,717.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 26,818,300.00 | 26,553,717.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 13 | 13 | 13 | 13 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | 10 | 10 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 2 | 2 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00 | 00 | 00 | 00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27